



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/334

Бсөнбулаг

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7, 37.1.8 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.2, 47.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Хөхморьт сумын соёлын төвийн барилгын их засварын ажлын гүйцэтгэл, тоо хэмжээг зураг төсөл, барилгын норм ба дүрмийн дагуу гүйцэтгэсэн эсэхийг нягтлан албажуулах, санхүүжилтийн гүйцэтгэлийн тооцоо нийлэх, үнэлэлт, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)
Гишүүд:	Ж.Мөнхчимэг	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн газрын харилцаа барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
	М.Отгонжаргал	(Соёл, урлагийн газрын төсөв, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)
	У.Батсүх	(Хөхморьт сумын Засаг даргын орлогч)
	Ч.Сумъяабэйс	(Хөхморьт сумын Соёлын төвийн эрхлэгч)
Нарийн бичгийн дарга:	Б.Цэрэндаваа	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Холбогдох хууль, журмын дагуу тухайн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд бодит үнэлэлт, дүгнэлт өгч, ажлын илтгэх хуудсыг нотлох баримтын хамт 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн дотор үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

C:/ My Documents A-4 doc

0201002190

